



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 10 сарын 20 өдөр

Дугаар А/543

Хэрлэн сум

Арга хэмжээ зохион байгуулж,
хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 16 дугаар хуралдааны "Хүнсний хувьсгал" үндэсний хөдөлгөөнийг батлах тухай 05 дугаар тогтоолуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1."Хүнсний хувьсгал" үндэсний хөдөлгөөнийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 4.2.3 дахь заалтыг хэрэгжүүлэх зорилгоор уламжлал болгон зохион байгуулагддаг "Хэнтий аймгийн аварга тогооч, зөөгч шалгаруулах ур чадварын" тэмцээн зохион байгуулахад зориулж, 7,000,000 (долоон сая) төгрөгийн хөрөнгө зарцуулсугай.


2.Шаардагдах зардлын тооцоог хавсралтаар баталсугай.

3.Дээрх хөрөнгийг аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн "Хүнсний хувьсгал" үндэсний хөдөлгөөний хэрэгжүүлэх зардлаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтэс (С.Нямдаваа)-т, захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Ж.Гантулга)-т тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ



Аймгийн Засаг даргын 2023 оны 10 дугаар сарын 20-ны дугаар захирамжийн хавсралт

ХЭНТИЙ АЙМГИЙН АВАРГА ТОГООЧ, ЗӨӨГЧИЙН
ТЭМЦЭЭНИЙ ТӨСӨВ

2023.10.17

№	Зардлын төрөл	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ
1	Цом	ш	3	150000	450000
2	Өргөмжлөл	ш	40	20000	800000
3	Талархал	ш	30	5000	150000
4	Батламж	ш	60	5000	300000
5	Гранпри төрөлд I байр /мөнгөн шагнал/	ш	3	70000	210000
6	Гранпри төрөлд II байр /мөнгөн шагнал/	ш	3	60000	180000
7	Гранпри төрөлд III байр /мөнгөн шагнал/	ш	3	50000	150000
8	Төрөл тус бүрд I байр /мөнгөн шагнал/	ш	9	80000	720000
9	Төрөл тус бүрд II байр /мөнгөн шагнал/	ш	9	60000	540000
10	Төрөл тус бүрд III байр /мөнгөн шагнал/	ш	9	40000	360000
11	Медаль /10 төрөл/	ш	40	10000	400000
12	Мандат	ш	70	1500	105000
13	Хэрэглэгдэх хүнсний материал			1400000	1400000
14	Хоолны хар хайрцагны материал /гранпри/, /сургууль, цэцэрлэг, эмнэлэг, оюутан/	ш	10	50000	500000
15	Бичиг хэргийн зардал			60000	60000
16	Анонс 4*6	м2	16000	24	384000
17	Бусад зардал				291000
БҮГД ҮНЭ					7000000